






## 1. ИНФЛЯЦИ



Улсын хэмжээнд инфляцийн төвшин 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 2.1 хувьтай байна.

Харин Улаанбаатар хотын ерөнхий инфляци 1.9 хувьтай байгаа бол суурь инфляци 3.2 хувьтай байна.


## 2. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ



Мөнгөний нийлүүлэлт 2016 оны 4 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 405 тэрбум төгрөгөөр буюу 4%-иар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 813.7 тэрбум төгрөгөөр буюу 8.38%-иар өсч 10,518.7 тэрбум төгрөг байна.



## 3. ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ

2016 оны 3 дугаар сарын байдлаар гадаад валютын нөөц 1.26 тэрбум ам.доллар болж өмнөх сараас 5.68%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 4.43%-иар буурчээ.




## 4. ХАДГАЛАМЖ



Нийт хадгаламж 4 дүгээр сарын байдлаар 7,629.4 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.9%-иар өсчээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 5,460.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх сараас 0.1%-иар буюу 6.4 тэрбум төгрөгөөр буурсан, өмнөх оны мөн үеийнхээс 348.8 тэрбум төгрөг буюу 6.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.



## 5. ЗЭЭЛ




2016 оны 4 дүгээр сарын эцэст нийт зээлийн өрийн үлдэгдэл 11,629 тэрбум төгрөгт хүрч өмнөх сарынхаас 198 тэрбум төгрөгөөр буюу 1.6%-иар буурсан ба өмнөх оны мөн үеийнхээс 667 тэрбум төгрөгөөр буюу 5.4%-иар буурсан байна.



Нийт зээлийн 9.2%-ийг чанаргүй зээл эзэлж байна.



## 6. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ




2016 оны 4 дүгээр сарын эцэст гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 745 тэрбум төгрөг болж өмнөх сараас 86.4 тэрбум төгрөгөөр буюу 13.1%-иар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 10.1 тэрбум төгрөгөөр буюу 1.3 %-иар өсчээ.

## 7. ГАДААД ДОТООД ЦЭВЭР АКТИВ

Гадаад цэвэр актив өмнөх сараас 1,437.5 тэрбум төгрөгөөр буюу 35.2%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 636.1 тэрбум төгрөгөөр буюу 19.4%-иар буурч -2,648.5 тэрбум төгрөг болов.



## 8. ХУДАЛДАН АВСАН АЛТНЫ ХЭМЖЭЭ (кг)



2015/4сар	536.7 кг
2015/5сар	895.4 кг
2015/6 сар	1,344.1 кг
2015/7 сар	1,647.6 кг
2015/8 сар	1,993.8 кг
2015/9 сар	2,793.5 кг
2015/10 сар	2,674.0 кг
2015/11 сар	1,518.4 кг
2015/12 сар	694.8 кг
2016/01 сар	644.1 кг
2016/02 сар	538.5 кг
2016/03 сар	679.5 кг
2016/04 сар	718.3 кг